



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/34

Ховд

Жуух бичгээр шагнах тухай

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е" заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эх орон, ард түмнийхээ төлөө өргөсөн тангарагтаа үнэнч байж, албан үүргээ нэр төртэй гүйцэтгэн хамт олноо манлайлан үр бүтээлтэй ажиллаж буй Шүүхийн шинжилгээний албаны гарын хээний санч, цагдаагийн ахлагч Т.Наранцэцэгийг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан Т.Наранцэцэгт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Шүүхийн шинжилгээний албаны дарга /Д.Цэрэндорж/-д зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ